



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.20 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагыг хөгжүүлэх шинэ санаа, технологийн төслийг шалгаруулах” болзолт уралдааныг 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаатай зарласугай.

2. Болзолт уралдааны зорилго, хамрах хүрээ, хугацаа, тавигдах шаардлага, дүгнэх, урамшуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, болзолт уралдааныг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Болзолт уралдаанд шаардагдах 6 000 000 (Зургаан сая) төгрөгийг Эрүүл мэндийн сайдын багцын зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т, болзолт уралдааныг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор шалгаруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Энхболд/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Оюунчимэгт үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080276



## **“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ХӨГЖҮҮЛЭХ ШИНЭ САНАА, ТЕХНОЛОГИЙН ТӨСЛИЙГ ШАЛГАРУУЛАХ” БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ”**

### **ҮНДЭСЛЭЛ**

Аливаа улс орны эрүүл мэндийн салбарын үндсэн зорилго нь нийт хүн амынхаа эрүүл мэндийн байдлыг сайжруулах явдал юм.

Сүүлийн хориод жилийн хугацаанд вирүсийн эсрэг эм бэлдмэл, биотехнологи, лаборатори, дүрс оношилгоо, эд эрхтэн шилжүүлэн суулгах, мэс заслын арга техник, мэдээллийн цахим технологи, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ зэрэгт эргэлтийн шинжтэй өөрчлөлтүүд гарсан хэдий ч өнөөдрийн хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Эдийн засгийн хомсдолтой, боломжит нөөцийн хэмжээ хязгаарлагдмал энэ үед эрүүл мэндийн байгууллагыг хөгжүүлэхэд дотоод нөөц бололцоогоо дайчлах, зөв хуваарилах, зөв зарцуулах, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашигтай шинэ санаа, технологийн төслийг шалгаруулах, нэвтрүүлэх шаардлагатай байна.

### **ЗОРИЛГО**

Эрүүл мэндийн байгууллагыг хөгжүүлэхэд дотоод нөөц бололцоогоо дайчлах, зөв хуваарилах, зөв зарцуулах эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашигтай шинэ санаа, технологийн төслийг шалгаруулах

### **ЧИГЛЭЛ**

1. Сумын эрүүл мэндийн төв
2. Өрхийн эрүүл мэндийн төв
3. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг
4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв

### **АГУУЛГА**

Шинэ санаа, технологийн төсөлд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалт
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ
4. Хүний нөөц
5. Санхүүжилт, урамшуулал

6. Техник, тоног төхөөрөмж
7. Салбар дундын хамтын ажиллагаа
8. Шатлал хоорондын уялдаа холбоо
9. Ёс зүй, харилцаа хандлага

#### **ХАМРАХ ХҮРЭЭ**

Бүх эрүүл мэндийн байгууллага, эрдэмтэн, профессор, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоод, ТББ

#### **УРАЛДААНД ИРҮҮЛЭХ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

1. Хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлсон байх;
2. Шинэ санаа, технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай өртөг зардал, хүний нөөц, дэд бүтэц, тогтолцооны зохион байгуулалтыг тооцоолсон байх;
3. Эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашгийг тооцоолсон байх;
4. Шинэ санаа, технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай удирдамж, гарын авлага, зааварчилгаатай байх.

#### **БОЛЗОЛТ УРАЛДААНЫ ШАГНАЛ**

Чиглэл тус бүрээс нэг төсөл шалгаруулна. Шалгарсан төсөл бүрд 1,500,000 төгрөг

#### **ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА**

2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 30 хоногийн хугацаанд зохион байгуулагдана.

#### **ДҮГНЭХ**

Уралдаанд ирүүлсэн материалыг уралдааныг дүгнэх ажлын хэсэг ажлын 10 хоногт багтаан шалгаруулж, удирдлагуудад танилцуулж шийдвэрлүүлнэ.



Эрүүл мэндийн сайдын 2016 оны  
09 сарын 30 өдрийн 122 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ХӨГЖҮҮЛЭХ ШИНЭ САНАА,  
ТЕХНОЛОГИЙН ТӨСЛИЙГ ШАЛГАРУУЛАХ” БОЛЗОЛТ УРАЛДААНЫГ  
ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**Ажлын хэсгийн дарга:** Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

**Гишүүд:**

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Оношилгоо, эмчилгээний технологийн албаны дарга

Мэдээлэл технологийн албаны дарга

**Нарийн бичгийн дарга:** Оношилгоо, эмчилгээний технологийн албаны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартын бодлогын хэрэгжилтийн нэгдсэн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн